# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 01 өдөр    Дугаар 119    Улаанбаатар хот

"Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг өөрчлөн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 18 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтцийг хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.

2. "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын орон тооны хязгаарыг 7132 (долоон мянга нэг зуун гучин хоёр) байхаар тогтоосугай.

3. Шинээр батлагдсан ажлын байрны тодорхойлолтыг баталж, батлагдсан төсөвт багтаан цалингийн зардлыг шийдвэрлэхийг "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Х.Бадамсүрэнд даалгасугай.

4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны ""Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт оруулах тухай" 552 дугаар тогтоолын 1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА    Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА    Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 20..-оны 01 дүгээр сарын 01-ны өдрийн ...119... дугаар тогтоолын хавсралт

## “ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

